



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/218

Булган

Комисс томилох тухай


Монгол улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Булган сумын “Битүү зах” худалдааны төвийн барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Комиссын дарга: - Б.Ганзориг /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга/
- Нарийн бичгийн дарга: - Н.Гүржав /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
- Гишүүд: - О.Ихбаяр /Аймгийн Ерөнхий архитектор/
- Т.Дорж /Төрийн архивын тасгийн дарга/
- Т.Хувьзаяа /Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга, улсын хяналтын ахлах байцаагч/
- Н.Очирхуяг /Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техник, авто замын хяналтын улсын байцаагч/
- Ж.Баасанжав /Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч/
- Ж.Эрдэнэбулган /Онцгой байдлын газрын Гал түймэрийн улсын хяналтын байцаагч, дэслэгч/
- Г.Отгонбаяр /“ЭБЦТС” ТӨХК-ийн Булган салбарын ахлах инженер/
- Д.Ням-Осор /“МХС” ТӨХК-ийн ерөнхий инженер/
- Г.Энхтайван /“Булган мээж” ХХК-ийн инженер/
- Х.Баттулга /“Булган мээж” ХХК-ийн инженер/
- П.Саран /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл/
- Ч.Сод-Эрдэнэ /“Виллкон” ХХК-ийн захирал/
- Ц.Алтансүх /“Их азар” ХХК-ийн захирал/

2. Булган аймгийн Булган сумын “Битүү зах” худалдааны төвийн барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг 2019 оны 04 дүгээр сарын 23-ны дотор багтаан зохион байгуулахыг комиссын дарга /Б.Ганзориг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190234